



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 24-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

## 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТҮҮД, 2026 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2026 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталсугай.
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгасугай.
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 24-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.13 дахь хэсэг, 2026 оны 04 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

### 1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн

#### 1.1 Ердийн гишүүнээр:

- 1.1.1 Б.Зориг
- 1.1.2 Д.Оюун
- 1.1.3 П.Сувдаа
- 1.1.4 Э.Пүрэвсүрэн
- 1.1.5 Ш.Ганзориг
- 1.1.6 Н.Мягмарсүрэн нарыг,

#### 1.2 Хараат бус гишүүнээр:

- 1.2.1 С.Цэнгэлмаа
- 1.2.2 П.Алтанцэцэг
- 1.2.3 М.Марат нарыг тус тус сонгосугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 24-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ, ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоол, Цалин урамшууллын хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны нийт төсвийг **173,000,000 /Нэг зуун далан гурван сая/ төгрөгөөр** баталсугай.
2. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн цалин хөлсийг дараах байдлаар тогтоосугай:
  - 2.1.Ердийн болон хараат гишүүн 1,000,000\*9 /сар бүр, гишүүн тус бүр/ төгрөг;
  - 2.2.Нарийн бичгийн дарга 1,500,000 /сар бүр/ төгрөг;
  - 2.3.Ажил албан тушаал хавсран гүйцэтгэх нэмэгдэл /Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга/ - 3,000,000 /сар бүр/ төгрөг;
  - 2.4.Албан тушаал хавсран гүйцэтгэх нэмэгдэл /комплайнсын ажилтан/ - 500,000 /сар бүр/ төгрөг.
3. Ажлын онцлогийг харгалзан Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын урамшуулал, нэмэгдэл цалин хөлсийг сар бүр /сар бүрийн 5 ба 20-ны өдрүүдэд/, бусад гишүүдийн урамшууллыг улиралд нэг удаа олгосугай.
4. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин хөлс, урамшуулал, нэмэгдэл цалин хөлснөөс хуульд заасан шимтгэл, татварыг тухай бүр суутган олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 24-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

## ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОХ, ТҮҮНТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭТГЭЭДЭД ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.6, 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, аудитын дүгнэлт гаргах байгууллагаар Монгол Улсын “Координат Про Консалтантс аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Координат Про Консалтантс аудит” ХХК-тай гэрээ байгуулах, ажлын хөлсний хэмжээг тохиролцох эрхийг тус компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлд олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



# МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 24-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

## ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 зүйлийн 62.1.10, 62.1.11, 62.1.15 дахь хэсэг, 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Баянхошуу дэд төвийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 5-р хорооны нутаг дэвсгэр дэх 12.6 гар талбарт гэр хорооллын газрыг дахин төлөвлөн, орон сууцжуулах төсөлтэй холбоотой “Материалимпэкс” ХК-ийн охин компани болох “Материалимпэкс констракшн” ХХК, “Материал кредит ББСБ” ХХК, харилцаа хамаарал бүхий компани болон “Термес” ХХК, “Материал Гласс” ХХК, “Материал проперти” ХХК-иудтай хамтран ажиллах, хөрөнгө оруулах, хөрөнгө татах сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрхийг Төлөөлөн Удирдах зөвлөлд олгосугай.
2. Мөн төслийн төсөвт өртгийн 75% хүртэлх дүнтэй тэнцэх хэмжээний буюу их хэмжээний хэлцэл хийж, гадаад болон дотоодын иргэн, аж ахуйн нэгжээс хөрөнгө оруулалт авах, хамтран ажиллах эрхийг Төлөөлөн Удирдах зөвлөлд олгосугай.
3. Төлөөлөн Удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээ, тайланг эрх бүхий байгууллага, хөндлөнгийн аудитын байгууллагад цаг тухайд нь мэдэгдэж, хууль, журмыг чанд мөдөн ажиллахыг үүрэг болгосугай.
4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн талаарх тайланг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН